

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт /2023 оны жилийн эцсийн байдлаар/

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр.

Шийд- вэрийн Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн, үр нөлөө	Өөрийн үнэлгээ /тайлбар/	ХШҮ- ний үнэлгэ э
Монгол улсын хууль							
2	2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;	Цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан эсэх	Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг мэдээллийн самбар болон байгууллагын www.sanhuaudit.gs.gov.mn цахим хаягт байршуулсан. Тайлант хугацаанд 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хяналт шалгалтын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, стратеги төлөвлөгөөг тус тус цахим хуудсанд байршуулсан. Тайлант хугацаанд цахим хуудсанд нийт 160 удаагийн мэдээллийг шинэчлэн байршуулсан. Үр дүн: https://sanhuuhyanal.gs.gov.mn/?page_id=55	100	
	3		8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;	Цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан эсэх	Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, байгууллагын утас, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягыг мэдээллийн самбар болон байгууллагын www.sanhuaudit.gs.gov.mn цахим хаягт бүрэн байршуулсан. Мөн байгууллагын 7 ажилтантай холбогдох утасны дугаарыг бөйршуулсан.	100	

					Үр дүн: https://sanhuuhyanal.gs.gov.mn/?page_id=51		
4		8.2.3. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйцаар мэдээллийн самбар болон байгууллагын www.sanhuuaudit.gs.gov.mn цахим хаягт байршуулсан. Мөн байгууллагын үйл ажиллагааны тайлан-1, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан-1, санхүүгийн тайлан-1, хяналт шалгалтын тайлан-23 нийт 26 тайланг байгууллагын вэб сайт болон шилэн дансны цахим хуудсанд тухай бүр нь байршуулсан. Үр дүн: 26 удаагийн тайлан мэдээг ил тод нээлттэй байршуулсан.	100	
5		8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	Цахим хуудсанд оруулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан	Цахим хуудсанд оруулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хагас жилийн тайланг байгууллагын www.sanhuuaudit.gs.gov.mn цахим хаягт байршуулсан. Үр дүн: 2023 оны эхний хагас жилийн тайланг байршуулсан.	100	
6		8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг	Байгууллагын дотоод хяналт шалгалтын журмыг байгууллагын даргын 2023.08.17-ны өдрийн А/16 дугаар тушаалаар, Хөдөлмөрийн дотоод журмыг байгууллагын даргын 2023.10.02-ны өдрийн А/23 дугаар тушаалаар тус тус шинэчлэн баталсан. Үр дүн: Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх 2 журам байршуулсан.	100	
7		8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль, тогтоомж, шийдвэрүүдийг иргэдэд харагдахуйц ил тод нээлттэй байршуулах	Байгууллагын дотоод үйл ажиллагаа болон хяналт шалгалттай холбоотой түгээмэл хэрэглэгддэг хууль-4, ЗГ-ын тогтоол-2, журам-2, дүрэм-1 тус тус байгууллагын www.sanhuuaudit.gs.gov.mn цахим хаягт байршуулсан. Үр дүн: Байгууллагын үйл ажиллагаанд түгээмэл хэрэглэгддэг 9 хууль, дүрэм, журмыг байршуулсан.	100	

	8		8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;	Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг цахим хуудаст байршуулах.	Байгууллагын www.sanhuaudit.gs.gov.mn цахим хаягт 7 албан хаагчдын албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар болон цахим шуудангийн хаягыг бүрэн байршуулсан. Үр дүн: 7 албан хаагчийн мэдээллийн ил тод байдал хангагдсан.	100	
	9		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Цахим хуудсанд байршуулсан эсэх	Өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн тайлан мэдээг www.sanhuaudit.gs.gov.mn цахим хуудсанд улирал тутам байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт гомдол шийдвэрлүүлэх тухай 1 хүсэлт, ээлжийн амралтын тухай 1 өргөдөл ирсэн бөгөөд гомдол шийдвэрлүүлэх тухай хүсэлт нь манай байгууллагатай хамааралгүй тул хуулийн дагуу буцаасан. Ээлжийн амралтын тухай 1 өргөдлийн хариуг 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 169 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. Үр дүн: иргэний өргөдөл гомдын шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд бүрэн шийдсэн.	100	
	10		8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	Цахим хуудсанд байршуулсан эсэх	Аймгийн 2022 оны статистик мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Үр дүн: Мэдээллийг ил тод болгосон.	100	
	11		8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	Зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон зохион байгуулсан арга хэмжээг тогтмол байршуулах	Байгууллагын цахим хуудас болон facebook хаягаар байгууллагаас зохион байгуулсан болон хамрагдсан арга хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр нь байршуулсан. Үүнд сургалтын талаарх мэдээлэл-6, мод бут тарилтын талаарх мэдээлэл-10, хог хаягдлын талаарх мэдээлэл-1, эссэ бичлэгийн талаарх мэдээлэл-2, хоггүй сүмбэр facebook хуудсанд-11, байгууллагын facebook хуудсаар-45 мэдээлэл тус тус байршуулсан.	100	

					Үр дүн: Хийгдсэн арга хэмжээний талаар нийт 75 мэдээллийг тухай бүр нь байршуулсан.		
	12		8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;	Цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан эсэх	Ажлын байрны сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 2 удаа, ХХҮГазраар 3 удаа, Төрийн захиргаа удирдлагын хэлтсээр дамжуулан 2 удаа зарлуулсан. Үр дүн: Байгууллага батлагдсан 7 орон тоогоор 100 хувь ажиллаж байна.	100	
	13		8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	Цахим хуудас, байгууллагын мэдээллийн самбарт байршуулах	Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам батлах тухай” тогтоолыг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан. Үр дүн: https://sanhuuhyanal.gs.gov.mn/?cat=20	100	
	14		8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрмийг цахим хуудсанд байршуулах	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын www.sanhuaudit.gs.gov.mn цахим хаягт байршуулсан. Үр дүн: https://sanhuuhyanal.gs.gov.mn/?page_id=703	100	
	15		8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;	“Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр”-ийг 4 жилээр төлөвлөн батлуулж цахим хуудсанд байршуулах	Төрийн албан хаагчдын сургалтын хөтөлбөр, Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл нийгмийн баталгаа хангах 4 жилийн хөтөлбөрийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Үр дүн: https://sanhuuhyanal.gs.gov.mn/?cat=12	100	
	16		8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;	цахим хуудасны хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг тогтмол шинэчлэх	Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг тайлант хугацаанд 2 удаа шинэчлэн байршуулсан. Үр дүн: Тайлант хугацаанд нийт 2 удаа мэдээллийг шинэчилсэн.	100	
	17		8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам болон албан хаагчдыг үнэлсэн	Байгууллагын цахим хуудсанд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаал “Төрийн жинхэнэ	100	

			үнэлгээг иргэдэд ил тод байдлаар цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах	албан хаагчийн гүйцэтгэл үр дүн мэргэжлийн түвшинг үнэлэх журам"-ыг болон албан хаагчдыг үнэлсэн байдлыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Үр дүн: 7 албан хаагчийн үнэлгээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.		
18		8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төслийг нийтэд мэдээлэх	Байгууллагын цахим хуудсанд 2022 оны төсвийн гүйцэтгэл, тухайн оны батлагдсан төсөв, 2023 оны төсвийн төсөл 2024 оны төсвийн төсөөлөлийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулсан. Үр дүн: Төсөв гүйцэтгэл 1-10 сар, 2024 оны төсвийн төслийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан.	100	
19		8.4.2. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас, шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	2023 оны 1-10 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар тутам, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг тухай бүр нь байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим хуудсанд байршуулсан. Үр дүн: 2022 оны санхүүгийн тайлан, 2023 оны хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан.	100	
20		8.4.3. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд оруулж, нийтэд мэдээллэсэн. Үр дүн: 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан.	100	
21		8.4.4. Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;	Төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоосон шийдвэрийг байгууллагын цахим хуудас	Манай байгууллагад төвлөрүүлэх төлбөр хураамж байхгүй болно.	-	

				болон шилэн дансанд байршуулах.			
22		8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг шилэн дансанд байршуулах	Төсвийн хэмнэлт, хэтрэлт түүний шалтгааны тайлбарыг шилэн дансы нэгдсэн цахим хуудсанд байршуулж хэвшсэн бөгөөд тайлант онд 10 удаагийн мэдээллийг оруулаад байна. Үр дүн: 2023 оны 1-10 сарын төсвийн гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан..	100		
23		8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд сар бүрийн 8-ны дотор шилэн дансы нэгдсэн цахим хуудсанд байршуулж хэвшсэн. Тайлант хугацаанд 10 удаагийн мэдээлэл оруулаад байна. Үр дүн: 2023 оны 1-10 сарын таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан..	100		
24		8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд оруулж, нийтэд мэдээлэх	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт байгууллагын шилэн дансны цахим хуудсанд сар бүрийн 8-ны дотор шилэн дансы нэгдсэн цахим хуудсанд байршуулж хэвшсэн. Тайлант хугацаанд 10 удаагийн мэдээлэл оруулаад байна. Үр дүн: 2023 оны 1-10 сарын цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг	100		

					шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан.		
25		8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	төсөв баталсан болон төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан тогтоолуудыг нийтэд мэдээлэх		Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байгууллагын шилэн дансны цахим хуудсанд сар бүрийн 8-ны дотор шилэн дансы нэгдсэн цахим хуудсанд байршуулж хэвшсэн. Тайлант хугацаанд 10 удаагийн мэдээлэл оруулаад байна. Үр дүн: 2023 оны 1-10 сарын бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан.	100	
26		8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;	Шилэн дансанд мэдээллийг бүрэн оруулж, нийтэд мэдээлэх		Аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд нь бүрэн оруулсан. Үр дүн: 2022 оны санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмж, түүний биелэлтийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан.	100	
27		8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	Төрийн аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт цахим хуудсанд байршуулах		Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тухай бүр оруулж хэвшсэн. Тайлант хугацаанд 1 удаагийн мэдээлэл оруулсан. Үр дүн: 1 удаагийн хяналт шалгалтын талаарх мэдээллийг оруулсан.	100	
28		8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;	Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт,		төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүнгийн талаар	100	

				хэрэгжилт, явц, үр дүнг цахим хуудсанд байршуулах.	шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулах мэдээлэл байхгүй. Үр дүн: Оруулах мэдээлэл байхгүй.		
	29		8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах.	Шилэн дансны цахим хуудас болон байгууллагын цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг тогтмол байршуулдаг. Энэ оны төлөвлөгөөг байршуулсан бөгөөд, тайланг байршуулах хугацаа болоогүй байна. Үр дүн: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байршуулсан.	100	
	30		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	Мэдээллийг тогтмол байршуулах	Холбогдох мэдээлэл байхгүй	-	
4	16	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	Тайлант хугацаанд нийт ажлын байран дахь сургалт-6, мэргэшүүлэх сургалт-4, цахим сургалт-4, танхим-16 нийт 30 сургалтанд 100 хувь хамрагдсан. Мөн тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой 7 удаагийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд давхардсан тоогоор 157 хүн хамрагдсан. Мөн ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах үүднээс тайлант онд 8209.5 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авч 2 албан хаагчид 1100,0 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, албан хаагчдын 16 хүүхдэд 800,0 мянган төгрөгийн бэлэг олгосон. Үр дүн: Хамрагдсан сургалт-30, Зохион байгуулсан сургалт-7, хамрагдсан хүн-157, байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан.	100	
Ерөнхийлөгчийн зарлиг							
3		Монгол бичгийн хэрэглээг	3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр	Сургалтанд хамрагдах	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс байгууллагын өрөө тасалгаа	100	

	31	нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Байгууллагын гадна хаяг болон алсын харааг Монгол бичгээр бичих	болон мэдээллийн самбар зэргийг монгол бичгээр хэвлүүлж хийсэн. Мөн цахим бичвэр боловсруулах арга аргачлалд сургах сургалтад хамрагдан албан хэрэг хөтлөлтийн mongrad программыг суулган албан хэрэг хөтлөлтдөө ашиглахаар хэвлэлтийн тохиргоог хийж байна. Үр дүн: Байгууллагын үйл ажмллагаанд монгол бичгийг ашиглаж эхэлсэн.		
5	34	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг хориглох, хяналт тавих	Манай байгууллага нь тайлант онд төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулсан албан ёсны баяр ёслол арга хэмжээнд оролцоогүй бөгөөд, архи согтууруулах ундааг хэрэглэхгүй байх талаар албан хаагчдад тогтмол мэдээлэл өгч ажилласан. Үр дүн: Нийтийг хамарсан арга хэмжээнд оролцоогүй, зөрчил гараагүй.	100	
	35		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах. Ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байх.	Архи согтууруулах ундааг хэрэглэхгүй байх талаар албан хаагчдад тогтмол мэдээлэл өгч ажилласан. Мөн ажлын байранд архи, согтууруулах ундааг хэрэглэхийг хориглодог бөгөөд, албан хаагчид албан байгууллага дээрээ архи согтууруулах ундаа хэрэглэдэггүй. Үр дүн: Байгууллагын 7 ажилтанд мэдээллийг хүргэсэн. Зөрчил гараагүй.	100	
		Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг	Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг мод тарих	ТЭР БУМ МОД" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Сүмбэр гарден" цэцэрлэгт хүрээлэнгийн зам дагуух 2014 оны ойн зурваст талбайд 2023 оны хавар 50ш мод нөхөн тарьж хуваарийн дагуу нийт 16 удаа усалгаа хийсэн. Мөн Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд 44ш мод тариалж намрын цэнэг усалгааг хийсэн. Тайлант онд нийт 94 мод тарьсан. Мөн хариуцсан талбайн мод арчлалт, хамгаалалт, талбайн зэрдэг зулгаах, орчны хог	100	

			хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах		хаягдлыг цэвэрлэх зэрэг ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. Үр дүн: Тарьсан модны тоо-94 үүнээс нөхөн тарьсан модны тоо-50, усалгаа хийсэн тоо-16		
		Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022-159	2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах	Байгууллагадаа Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залсан. Үр дүн: Албаны даргын өрөөнд залсан.	100	
			3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай.	Албан хаагчдаа уриалах	Албан хаагчдаа Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалан ажилласан. Үр дүн: Нийт 7 албан хаагчид уриалга гаргаж ажилласан.	100	
			4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Албан хаагчдаа уриалах	Албан хаагчдад Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсан. Үр дүн: Нийт 7 албан хаагчид уриалга гаргаж ажилласан.	100	
3Г-ын тогтоол							
6	36	ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257	2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.	Угийн бичиг хөтлөх сургалтад хамрагдах Албан хаагчдын угийн бичгийг хөтлүүлэх	2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Соёл урлагын газарт хүсэлт гарган угийн бичиг хөтлөлтийн талаарх сургалтыг хийлгүүлсэн. Сургалтад байгууллагын бүх албан хаагч хамрагдсан бөгөөд байгууллагын 7 албан хаагч угийн бичгээ хөтөлж эхэлсэн. Үр дүн: 7 албан хаагч 4 үеийн угийн бичгээ хөтөлсөн.	-	
9	39	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан	Төрийн албан хаагчдыг богино хугацааны сургалтад хамруулах	Алсын хараа-2050 болон Шинэ сэргэлтийн бодлогын 2 хоногийн танхимын болон 1 сарын цахим сургалтад байгууллагын албан хаагчид 100 хувь хамрагдаж, батламжаа авцгаасан.	100	

		2022-04-06 Дугаар 2022_139	хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.		Үр дүн: Байгууллагын 7 албан хаагчид 100 хувь хамрагдаж, батламжаа авсан.		
	40		3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг “Удирдлагын академи”-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Төрийн албан хаагчдыг богино болон дунд хугацааны сургалтад Удирдлагын академиас ирүүлсэн квотын дагуу хамаруулах	Тайлант онд 2 албан хаагч төрийн албан хаагчыг дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамруулсан. Үр дүн: 2 албан хаагч мэргэшүүлэх сургалтад хамрагдаж сертификатад авсан.	100	
10	41	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_203	1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай: 1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх; 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ,	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах	2023 онд 232482.6 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд 2023.09 сард төсвийн өөрчлөлт орж 243182.6 мянган төгрөг болсон. Эхний 10 сарын байдлаар 201360.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 184818.1 мянган төгрөгийг зарцуулан зардлын гүйцэтгэл 91.8 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотойгоор бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг 9.8 хувиар хэмнэсэн байна. Тухайн тайлант хугацаанд өр, авлага үүсээгүй. Мөн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Үр дүн: Тайлант хугацаанд хууль бус томилгоо хийгээгүй мөн хориглосон хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй.	100	

			онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; 1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.				
11	42	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Байгууллагуудын гадна болон дотор хаягжилтийг 85 хувьд хүргэх, төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ	Манай байгууллага нь гадна хаяг хийх шаардлаггүй. Харин дотор хаягыг 100 хувь монгол бичиг болон крилл бичгээр хосолмол болгосон. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор 7 хоногийн цахим сургалтад хамрагдан шалгалтаа амжилттай өгч сертификатаа авсан. Үр дүн: Байгууллагын 7 албан хаагчид 100 хувь монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй болсон.	100	
	43	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион	1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн	Алсын хараа – 2050 сургалтад хамрагдах	Алсын хараа-2050 болон Шинэ сэргэлтийн бодлогын 2 хоногийн танхимын болон 1 сарын цахим сургалтад байгууллагын 7 албан хаагч	100	

		байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.		100 хувь хамрагдаж, батламжаа авцгаасан. Үр дүн: 7 албан хаагч батламжаа авсан.		
	44	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204	9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.	Авто машины хэрэглээг хязгаарлах	Манай байгууллагад авто машин байхгүй	-	
	45	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн	Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурших иргэдийг нэмэгдүүлэх	Манай байгууллагын 7 албан хаагчаас 1 албан хаагч Улаанбаатар хотын харъяа байсан бөгөөд тус албан хаагч шилжин ирсэн. Үр дүн: Байгууллагын албан хаагчид 100 хувь орон нутгийн харъятай болсон.	100	

			сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./				
	46	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг хангах.	Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах	2023 онд 232482.6 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд 2023.09 сард төсвийн өөрчлөлт орж 243182.6 мянган төгрөг болсон. Эхний 10 сарын байдлаар 201360.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 184818.1 мянган төгрөгийг зарцуулан зардлын гүйцэтгэл 91.8 хувьтай байна. Үр дүн: Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн 8,2 хувь нь хэмнэгдсэн.	100	
	47	Төрийн албаны зарим албан тушаалын	2.Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан	Цалингийн доод хэмжээг шинэчлэн батлах	Тайлант онд цалингийн доод хэмжээ шинэчлэгдсэнтэй холбоотой албан	100	

		цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241	шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.		хаагчдын цалин, нэмэгдлийг 2 удаа шинэчлэн тогтоосон. Үр дүн: 1 албан хаагчид мэргэшсэн нягтлан бодогчийн зэргийн нэмэгдлийг олгосон. 2 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг ахиулж, 1 албан хаагчид шинээр олгосон.		
		Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-03-01 Дугаар 2023-79	3.Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах	Тайлант хугацаанд хийгдэх хяналт шалгалтын төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр батлуулсан. Үр дүн: Төлөвлөгөөний дагуу 80 хяналт шалгалт хийсэн.	100	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
13	49	2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл 2021-10-13 Дугаар 2021_55	ХҮ.13.6. “Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад;	“Худалдан авах ажиллагааны цахим систем”-д тендер шалгаруулалтын үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулах.	Манай байгууллага тайлант онд тендер шалгаруулалт зохион байгуулаагүй.	-	
14	50	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	Төрийн байгууллагуудад дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлэх И-Монголиа системд орон нутгаас үзүүлж буй төрийн үйлчилгээнүүдийг холбох	Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системийг байгууллагадаа бүрэн нэвтрүүлж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж хэвшсэн. Тайлант онд 204 баримт бичгийг цахимжуулсан. Үр дүн: Байгууллагаас явуулсан болон байгууллагад ирүүлсэн нийт 204 албан бичгийг илгээж хүлээн авсан.	100	
15	51	2022 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 12 дугаар тэмдэглэл	X.5. . 2021 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн	1. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг олон сувгаар хүлээн авах 2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн	Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цаасаар, утсаар, цахим шуудангаар авч байна. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар гомдол шийдвэрлүүлэх тухай 1 хүсэлт, ээлжийн амралтын тухай 1		

		2022-02-23 Дугаар 2022_12	талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хууль тогтоомжийн хүрээнд судлан иргэнд заавал хариу өгч байх, нэг асуудлаар олон дахин хандаж байгаад дүгнэлт хийж тухайн асуудлыг нэг мөр үндэслэлтэй шийдвэрлэж байх арга хэмжээ авч ажиллахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов.	өргөдөл, гомдлыг хүлээн авч, хугацаанд нь шийдвэрлэх	өргөдөл ирсэн бөгөөд гомдол шийдвэрлүүлэх тухай хүсэлт нь манай байгууллагатай хамааралтгүй байсан тул холбогдох газарт нь буцаасан. Ээлжийн амралтын тухай 1 өргөдлийн хариуг 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 169 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. Үр дүн: Бичгээр ирүүлсэн 1 өргөдлийг шийдвэрлэсэн.		
	52	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Байгууллагын албан бичгийг цахим хэлбэрээр солилцох	Албан хэрэг хөтлөлтийг ERP систем болон албаны и-мэйл хаягаар илгээж байгаа бөгөөд ERP системд байгууллагын нийт албан хаагчдыг бүртгэн эрхүүдийг нээж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Ирсэн явсан бичгийн бүртгэлийг тогтмол хөтлөн ERP системээр 10 сарын байдлаар нийт 204 албан бичгийг солилцон үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд: - Ирсэн бичиг -85 - Явсан бичиг – 119 тус тус байна. Үр дүн: ERP систем бүрэн нэвтэрсэн.	100	
ЗГ-ын албан даалгавар							
16	53	Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 Дугаар 2020_2	1.5. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах;	Байгууллагад тоон гарын үсэг нэвтрүүлэх.	Байгууллагад тоон гарын үсгийг нэвтрүүлсэн бөгөөд санхүүгийн тайлан мэдээг тоон гарын үсгээр илгээж байна. Үр дүн: Санхүүгийн 16 тайланг тоон гарын үсгээр илгээсэн.	100	
	54		3. Хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Цахим гарын үсгийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй хоблогдуулан хуульд заасан бусад тохиолдолд иргэний хурууны хээг таниулж үйлчилгээ үзүүлж байгааг үе		Манай байгууллагын албан хаагчид 100 хувь тоон гарын үсэг авсан. Үр дүн: Байгууллагын 7 албан хаагч 100 хувь тоон гарын үсгээ авсан.	100	

			шаттай зогсоох, төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг нэвтрүүлэх нөхцлийг бүрдүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, хууль, хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагын дарга, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирал нарт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэгн хариуцагч Л.Энх-Амгаланд тус тус үүрэг болгосугай.	Албан хаагчдыг тоон гарын үсэгтэй болгох		
	55		4. Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр нийтэлж байхыг Засгийн газрын гишүүд, хууль, хяналтын байгууллагын удирдлага, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн Гүйцэтгэх захирал нарт тус тус даалгасугай.	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан ил тод болгож байна. Тайлант хугацаанд цахим хуудсанд нийт 160 удаагийн мэдээллийг шинэчлэн ил тод болгосон. Мөн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 139 удаагийн мэдээллийг ил тод болгосон. Үр дүн: Нийт 299 мэдээллийг ил тод болгосон.	100
17	56	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6	1. 1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах;	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах	Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогын зорилго зорилт, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх арга хэмжээний талаар байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Албан хаагчид сургалтад 100 хувь хамрагдсан. Үр дүн: Байгууллагын 7 албан хаагчид 100 хувь сургалтад хамрагдсан.	100

Тайлан гаргасан: СХДАА-ны дарга

/Н.Алтанцэцэг/